



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2017 оны 05 сарын 16 өдөр

Дугаар 76

Номгон

“Торгон сүрэг” аймгийн дэд
хөтөлбөр батлах тухай

Аймгийн Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн 3 дугаар бүлгийн 94 дэх заалтыг хэрэгжүүлэх зорилгоор аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. “Торгон сүрэг” аймгийн дэд хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.

2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны нарийвчилсан төлөвлөгөө гарган, жил бүрийн аймгийн нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэл болон төсөвт тусгаж үе шаттайгаар хэрэгжүүлж, хөтөлбөрийн явц, биелэлтийн талаар тухайн оны эцэст аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанд танилцуулж байхыг аймгийн Засаг дарга /Г.Батжаргал/-д даалгасугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /С.Үнэнбуян/-д үүрэг болгосугай.

ДАРГА

Ц.ОТГОНБАЯР

0117187

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2017 оны 05 дугаар сарын
16-ны өдрийн 76 дугаар тогтоолын хавсралт



“ТОРГОН СҮРЭГ” АЙМГИЙН ДЭД ХӨТӨЛБӨР

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Аймгийн эдийн засгийн үндсэн салбар болсон хөдөө, аж ахуй нь дотоодын нийт бүтээгдэхүүний 50-иас дээш хувийг үйлдвэрлэж хөдөлмөр эрхлэлтийн 60-иас дээш хувийг эзэлж байна. Мал сүргийн тоо толгой жил дараалан нэмэгдэж 2016 оны байдлаар 4,2 саяд хүрлээ. Гэвч бэлчээрийн даац хэтэрсэн, малын төрөл хоорондын харьцаа алдагдсан, малын чанар буурч, ашиг шим өндөртэй цөм сүргийн малын тоо нийт мал сүрэгт 8 хувьд ч хүрэхгүй байгаа, малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлт, борлуулалтын нөхцөл хязгаарлагдмал, малчид сайн дураараа нэгдэж хоршоо бүлгийн зохион байгуулалтад ороогүй, байгаль цаг уурын эрсдэл даах болон зах зээлд өрсөлдөх чадвар төдийлөн сайн биш байгаа нь сөргөөр нөлөөлж байна.

Сүүлийн жилүүдэд Залаажинст-Эдрэнгийн цагаан ямаа үүлдрээр, Бөмбөгөрийн улаан ямаа омгоор батлагдаж Ламын гэгээний улаан тэмээ, Баянбулаг хонь хянан магадлуулах шатандаа явж байгаа боловч тэдгээрийн генетик нөөцийг бүрэн ашиглаж чадахгүй, цаашдын стратеги төлөвлөгөө батлагдаагүй байна.

Мал аж ахуйн салбарын талаар төрөөс бодлогын баримт бичиг цөөнгүй гарч үндэсний болон дэд хөтөлбөрүүд батлагдсан ч хэрэгжилт үр дүн нь дэвшүүлсэн зорилтоо хангаж чадахгүй, малыг тоогоор биш чанараар өсгөх талаар малчдын сэтгэхүй жигд өөрчлөгдөж чадаагүй зэрэг нь нөлөөлж байна.

Мал аж ахуйн салбарын тогтвортой хөгжлийг хангах, малын чанарыг сайжруулах нь дээр үеэс уламжлагдан мөрдөж ирсэн үржлийн шилмэл малын торгон сүргийг бүрдүүлэх, шилмэл хээлтүүлэгч бойжуулах, газар нутаг, байгаль цаг уур, тухайн малын онцлогыг харгалзан мал сүргийг бүсчилэн үржүүлэх нь энэ хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэх үндэслэл болж байна.

ХОЁР. ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

2.1 Мал аж ахуйг уур амьсгалын өөрчлөлт, бэлчээр нутгийн хүрэлцээ хангамж, нийгмийн хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн хөгжүүлж зах зээлд өрсөлдөх чадвартай эдийн засгийн үр ашигтай салбар байх нөхцөлийг бүрдүүлж, хүн амыг эрүүл аюулгүй хүнсээр, боловсруулах үйлдвэрийг чанартай түүхий эдээр хангаж нэгжээс ашиглах

бүтээгдэхүүний хэмжээ, аймаг орон нутаг, малчдын орлогыг нэмэгдүүлэх, орон нутагтаа сайн чанарын хээлтүүлэгч бэлтгэхэд хөтөлбөрийн зорилго оршино.

2.2 Дараах зорилтыг дэвшүүлж ажиллана.

2.2.1 Аймаг, сумын түвшинд мал үржлийн алба, тасаг, нэгжийн чадавхийг бэхжүүлэх.

2.2.2 Мал сүргийг төрөл, ашиг шимийн чиглэл, газар нутгийн байршлаар нь төрөлжүүлэн үржүүлэх.

2.2.3 Торгон сүрэг бүрдүүлэх, гойд ашиг шимт мал өсгөх, удамшлын чадавхыг дээшлүүлэх.

2.2.4 Мал сүргийг эрсдэлээс хамгаалах малчин өрхийн орлого, амьжиргааны түвшинг дээшлүүлэх.

2.3 Хэрэгжүүлэх үйл ажиллагаа

2.3.1 Мал үржлийн алба, тасаг, нэгжийн чадавхыг бэхжүүлэх зорилтын хүрээнд:

а. Хөтөлбөрийн зорилго, зорилтуудыг хэрэгжүүлэхийн тулд мэргэжлийн байгууллага, мэргэшсэн ажилтны удирдлага, шинэ технологид түшиглэн явуулна.

б. Аймгийн мал аж ахуйн алба, сумдын МЭҮ-ийн тасаг, мал үржлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжүүдэд мал зүйч мэргэжилтэн ажиллуулж тэднийг чадавхжуулах, мэргэжил дээшлүүлэх болон бусад сургалтад хамруулна. Сумдын мал эмнэлэг, үржлийн тасгийг мэргэжлийн, бүрэн орон тоогоор ажиллуулна.

в. Үржлийн шилмэл малыг бүртгэлжүүлэх, эзэмгэж тамгалах, мэдээллийн сүлжээ бий болгох, ашиг шимийн гарц, чанарыг тогтоох зэрэг ажлыг мэргэжилтний удирдлага, хяналтын дор явуулна.

г. Малын удамшлын нөөц, чадавхыг зохистой ашиглах, үржлийн ажлын болон баталгаажсан үүлдэр, омгийн малын стратеги төлөвлөгөө батлуулан хэрэгжүүлнэ.

д. Малчид, иргэдэд сургалт зохион байгуулж зөвлөмж, аргачлалаар хангана.

2.3.2 Мал сүргийг төрөлжүүлэн үржүүлэх зорилтын хүрээнд :

а. Тэмээний ноос, сүү ашиг шимийг нэмэгдүүлэх, уналга эдэлгээ, аялал жуулчлал, хязгаарлагдмал хүрээнд хурдлах чадварыг дээшлүүлэх чиглэлээр говын бүсийн сумдад өөр дотор нь үржүүлэхийн зэрэгцээ Галбын говийн улаан, Ханын хэцийн хүрэн, Төхөм тунгалагын хүрэн тэмээгээр сайжруулж болно.

б. Монгол адууг уналга эдэлгээ, хурдлах чадварыг нь дээшлүүлэх, мах, сүү ашиг шимийг нэмэгдүүлэх чиглэлээр өөр дотор нь үржүүлэхийн зэрэгцээ хурдны чиглэлээр дотоод, гадаадын сайжруулагч ашиглаж болно.

в. Монгол үхрийг өөр дотор нь цэврээр үржүүлэхийн дээр мах, сүүний чиглэлийн сайжруулагч ашиглаж болно. Сарлагийг хангайн бүсийн сумдад цэврээр үржүүлнэ.

г. Нутгийн монгол хонийг махны чиглэлээр дагнан үржүүлж Баяд, Байдраг, Барга, Торгууд зэрэг үүлдрийн хониор сайжруулна.

д. Ямааг говийн бүсэд Залаажинст-Эдрэн үүдрээр, тал хээр, хангайн бүсэд Бөмбөгөрийн улаан болон бусад үүлдэр омгоор сайжруулан үржүүлнэ.

е. Аймгийн төв томоохон суурингуудын ойролцоо мах сүүний үхэр, махны хонь, гахай, тахиа үржүүлэхийг дэмжинэ.

2.3.3 Торгон сүрэг бүрдүүлэх, гойд ашиг шимт мал өсгөх, удамшлын чадавхыг дээшлүүлэх зорилтын хүрээнд:

а. Торгон сүрэг нь өмчлөлийн хувьд төрийн болон хувийн гэсэн хэлбэртэй байж болох бөгөөд төр, хувийн хэвшил хамтарч хоршиж ажиллана. Торгон сүргийг малын төрөл, газар нутаг, засаг захиргааны нэгжээр бүрдүүлж болно

б. Аймгийн ХХААГ-ын харьяанд махны чиглэлийн хонины, ноолуурын чиглэлийн ямааны, Баянлиг, Богд сумдад Ламын гэгээний улаан тэмээний, Баян-Өндөр сумдад Хос зогдорт тэмээний, Баацагаан, Баян-Овоо, Өлзийт, Богд сумдад нутгийн монгол адууны, Эрдэнэцогт, Жаргалант сумдад сарлагийн, Эрдэнэцогт зэрэг сарлаг бүхий зарим сумдад хайнаг үхрийн, Баацагаан сумд нутгийн монгол үхрийн, Бөмбөгөр, Баянхонгор, Өлзийт, Баян-Овоо сумдад мах сүүний чиглэлээр сайжруулсан үхрийн, Жаргалант сумд Байдраг үүлдрийн хонины, Баянбулаг сумд Баянбулаг хонины, Галуут сумд барга үүдрээр сайжруулсан хонины, Шинэжинст сумд Залаажинст-Эдрэн үүлдрийн ямааны, Бөмбөгөр сумд Бөмбөгөрийн улаан омгийн ямааны тус бүр нэг торгон сүргийг зохион байгуулна. Малчдын захиалга сонирхлын дагуу тухайн орон нутагт зохицсон Эрчмийн хар, Торгууд зэрэг үүлдэр, омгийн малаар суурь зохион байгуулж болно. Торгон сүргийн мал тухайн сумдаа суурилагдах бөгөөд аймгийн ХХАА-н газар, сумдын МЭҮ-ийн тасаг, нэгжийн удирдлага, хяналтын дор үйл ажиллагаа явуулна.

в. Торгон сүрэг бүрдүүлсэн сум, өрх, суурийн малд жил бүр ангилалт шилэн сонголт үзлэг, аттестатчлалыг мэргэжилтний оролцоотойгоор хийж, үржлийн мал бойжуулж борлуулах эрх олгоно. Бог малын хээлтүүлэгчийн хүрэлцээ, хангамжийг нэмэгдүүлэхийн зэрэгцээ зохиомол хээлтүүлэг зэрэг дэвшилтэт технологийг хэрэгжүүлнэ.

г. Малын ашиг шимийн гарц, чанарыг тогтоох, гойд ашиг шимт малын үзэсгэлэн яармаг зохион байгуулах ажлыг жил бүр сум, аймагт зохион байгуулж улс бүсийн чанартай арга хэмжээнд оролцоно. Аймгийн ХХАА-н газар, сумдын Засаг дарга, мэргэжилтнүүдтэй байгуулах гэрээ, ажил дүгнэх үзүүлэлтэд Торгон сүрэг хөтөлбөрийн хэрэгжилтийг заалт болгон оруулж идэвхтэй ажилласан хүмүүсийг төр засаг, орон нутгийн шагнал, урамшилд эхний ээлжинд тодорхойлно.

д. Бог малын хээлтүүлэгчийг ялган суурилж үзлэг, ангилалтад хамруулан мэргэжилтэн, мэргэжлийн байгууллагын хяналтын дор тэргүүний малчдаар маллуулна.

е. Торгон сүргийн 1 суурьт байх малын тоо бод мал-100, бог мал 300-иас цөөнгүй байна.

ё. Торгон сүргийн малын нэгжээс авах ашиг шимийн хэмжээ /ноос, сүү, мах гм/ нутгийн малын ашиг шимийн дунджаас 20-иос доошгүй хувиар илүү байна. Төрийн зүгээс торгон сүрэг бүрдүүлэхэд гарааны хөрөнгө оруулалт хийж бог малын хээлтүүлэгч худалдан авахын дээр хувийн хэвшлийн санаачилга, оролцоог эрх зүй, эдийн засгийн талаас нь дэмжинэ. Торгон сүргийн малын өвс, тэжээл, даатгалын зардлыг төр хариуцна.

2.3.4 Мал сүргийг эрсдлээс хамгаалах малчин ерхийн орлого, амьжиргааны түвшинг дээшлүүлэх зорилтын хүрээнд:

а. Малын генетик нөөцийн тухай болон бусад хууль тогтоомж, аймаг орон нутгийн бодлого тодорхой болсон байна.

б. Үржлийн мал бойжуулж борлуулах эрх бүхий ААН, малчид, иргэдийг сонгон шалгаруулж тэдгээрийг дэмжих, урамшуулах хөшүүрэг бий болгох.

в. Малын чанар сайжруулах, торгон сүрэг бүрдүүлэх ажилд төсөл хөтөлбөрийн байгууллагуудыг оролцуулах.

е. Мал сүргийн 50-иас доошгүй хувийг даатгалд хамруулах.

ё. Монгол мал хөтөлбөр, Төрөөс малчдын талаар баримтлах бодлого, үндэсний болон бусад хөтөлбөрт малын чанарыг сайжруулах үржлийн шилмэл сүрэг бий болгох талаар азасан зорилтуудыг хэрэгжүүлэх.

ж. Мал сүргийг мал эмнэлэг, үржлийн ажил үйлчилгээнд бүрэн хамруулах, өвс тэжээл, хашаа хороо, худаг ус бусад нөөцөөр хангах.

ГУРАВ. ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ, УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

3.1 . Хөтөлбөр хоёр үе шаттай байх ба эхний үе нь 2017-2020 он, 2 дахь үе нь 2020-2025 онд хэрэгжүүлнэ.

3.2 Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг аймаг сумын түвшинд тухайн шатны Засаг дарга хариуцаж төлөвлөгөө боловсруулж баталсан байна.

3.3 Хөтөлбөрт тусгагдсан мал аж ахуйн үйлдвэрлэлийн ажил үйлчилгээг аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар, сумдын Мал эмнэлэг, үржлийн тасаг хариуцаж бусад төсөл, хөтөлбөрүүдтэй уялдуулан зохицуулах, энэ чиглэлийн үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагууд, малчид, иргэдийн оролцоотойгоор хэрэгжүүлнэ.

ДӨРӨВ. ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭХ ҮР ДҮН

4.1 Мал үржлийн ажил үйлчилгээ эрхэлдэг байгууллага, аж ахуйн нэгж, мэргэжилтний чадавх, ажлын үр өгөөж, бүтээмж дээшилсэн байна.

4.2 Мал сүргийг төрөл, ашиг шим, газар нутгийн байршлаар нь төрөлжүүлэн өсгөж, малын чанар сайжирсан байна. Бүх мал сүргийн 10-аас доошгүй хувь нь ашиг шим өндөртэй торгон сүргийн мал байна.

4.3 Бүх төрлийн малын торгон сүрэг бүрдэж, гойд ашиг шимт малын тоо жил дараалан нэмэгдэж нэгжээс бэлтгэх бүтээгдэхүүний хэмжээ өссөн байна. Хөтөлбөрийн

эхний үе шатанд бог малын хээлтүүлэгчийн 20 хувь, хөтөлбөрийн 2 дахь үе шатанд 50 хувийг төр мэдэлдээ авсан байна.

4.4 Мал сүргийг эрсдэлээс хамгаалах нөхцөл бүрдэж малчин өрхийн орлого нэмэгдэн улмаар аймаг орон нутгийн эдийн засаг сайжирсан байна.

ТАВ. ХӨТӨЛБӨРИЙН САНХҮҮЖИЛТ, ТАЙЛАН МЭДЭЭ

5.1 Малчид, мал бүхий иргэдийн хөрөнгө хандив тусламж

5.2 Аж ахуйн нэгж, байгууллагын хөрөнгө

5.3 Аймаг, сумын төсвөөс олгох хөрөнгө

5.4 Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө /Сумын ОНХС-н хөрөнгийн 30-иас доошгүй хувийг торгон сүрэг бүрдүүлэхэд зарцуулах/

5.5 Төсөл хөтөлбөрийн байгууллагын хөрөнгө

5.6 Бусад эх үүсвэр

Хөтөлбөрийн санхүүжилтийн эх үүсвэр түүний хуваарилалт, зарцуулалтад тавих хяналтыг холбогдох хууль тогтоомжийн дагуу хийж санхүүгийн мэдээ тайланг холбогдох байгууллага, хандивлагч, ивээн тэтгэгчид мэдээлж байна. Хөтөлбөрийн явц, биелэлтийн талаар аймгийн Засаг даргын зөвлөлд жил бүрийн I улиралд тайлагнана.